

Монгол Улс
НЭЗХДШ-ТС-ийн баримт бичгийг боловсруулах хүрээнд Хэнтий аймгийн
хувийн хэвшлийн байгууллагуудтай хийсэн уулзалт
2017 оны 10-р сарын 6

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор Хэнтий аймгийн хувийн хэвшлийн 16 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний баримт бичигт ирүүлсэн санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол улс хөдөө аж ахуйн орон бөгөөд энэ салбар цаашид улс орнын хөгжүүлэх тулгын чулуу болох ёстой. • Хэнтий аймагт Чингис хаантай холбоотой түүхэн дурсгалт газрууд ихтэй учраас аймгийн хөгжил, ажлын байр бий болгох томоохон боломж нь аялал жуулчлалын салбар юм. <p>Сорилтууд:</p> <p>Хөдөө аж ахуй</p> <ul style="list-style-type: none"> • Малын өвчин, экспортын зах зээлийн хүртээмжгүй байдлын улмаас Монгол улс боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тулгуурласан экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох хэрэгтэй. • Газар тариалангийн үйлдвэрлэл, хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх шинэ технологийг хөгжүүлэх, өргөн уудам газар нутаг, дотоодын зах зээлтэй учраас улс орны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх нь зүйтэй. • Мал аж ахуйг сайжруулах шинэ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэрэг мал аж ахуйн салбарт илүү дэвшилтэт орчин үеийн технологийг нэвтрүүлэх хэрэгтэй. • Ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ болон тэдгээрийн экспортыг өргөн цар хүрээтэйгээр дэмжин хөгжүүлэх шаардлагатай. <p>Боловсрол</p> <ul style="list-style-type: none"> • Ядуурлын өнөөгийн нөхцөл байдал нь боловсролын бодлого, тогтолцоотой нягт уялдаа холбоотой. Маш олон тооны их дээд сургууль байгаа ч техник

мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага (ТМБС) цөөн байна. Эцэг эхчүүд хүүхдүүдээ их дээд сургуульд явуулахын тулд өндөр хүүтэй банкны зээл авч байгаа нь ядуурлыг нэмэгдүүлэх шалтгаан болдог.

- ТМБС-ын байгууллагуудыг илүү дэмжин хөгжүүлснээр хүүхдүүд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцах хүсэл сонирхолтой болж, сургуулиа төгссөний дараа "бодит" салбаруудад ажиллах боловсон хүчин болж бэлтгэгдэх юм.

Засаглал

- Засаглалыг сайжруулж, бодлогын тогтвортой байдлыг хангах нь тэргүүлэх ач холбогдолтой. Улс төрийн нэг намын дэвшүүлсэн бодлогыг нөгөө нам эсэргүүцдэг. Улс төрийн тогтворгүй байдал нь бизнест нөлөөлж байна. Түүнчлэн бизнест улс төрийн оролцоо, нөлөө хэт их байна.
- Бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг.
- Хэдийгээр орон нутгийн засаг захиргаа орон нутгийн төсвийг захиран зарцуулах эрх мэдэлтэй байгаа ч орон нутгийн төсөвт улс төрийн хөндлөнгийн оролцоо, нөлөө их байгаагаас орон нутгийн төсвийн үр дүн, зэрэг үр өгөөж бага байна.
- Иргэдийн оролцоо сул, иргэдийн хэрэгцээ, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн талаар ард иргэдтэй зөвлөлддөггүй. ИНБ-ууд санхүүжилтгүйн улмаас үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй тулгардаг.

Уул уурхай

- Байгалийн нөөцийн менежмент нь тэргүүлэх чиглэл байх ёстой. Уул уурхайн нөөцийг цөөн тооны хүмүүс ашигладаг учраас баялгийн үр өгөөжийг нийт ард иргэд хүртдэггүй, улмаар энэ нь тэгш бус байдлыг нэмэгдүүлэх шалтгаан болдог.

Хувийн хэвшил

- Төр, засгийн газрын хүнд суртал хувийн хэвшлийг хөгжүүлэхэд саад учруулж байна. Тусгай зөвшөөрөл авахад маш хэцүү, тусгай зөвшөөрлийг шалгуурыг хангасан компаниудад олгогддоггүй, танил талдаа олгодог. Лиценз, зөвшөөрөл авах үйл явц, зохицуулалтыг хялбарчилж, боловсронгуй болгох шаардлагатай.
- Төрөөс бизнесийг зохицуулах зохицуулалт муу, бизнесийн үйл ажиллагаа, өрсөлдөх чадвараас хоцрогдсон. Жишээ нь Хэнтий аймгийн төвд шатахуун түгээх станцын зөвшөөрөл хэтэрхий олныг олгосон нь зах зээлд нийлүүлэлтийн илүүдлийг бий болгож байна. Хувийн хэвшлийн компаниудыг дэмжих зах зээлийн судалгаа, шинжилгээ дутмаг байна.
- Санхүүгийн програм хангамж, компаниудын санхүүгийн менежментийг сайжруулах, энэ чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нь хувийн хэвшлийн компаниудад их хэрэгтэй юм. Жижиг, дунд бизнес эрхлэгчид санхүүгийн програм хангамжийн хүрэлцээ хүртээмж дутмаг учраас санхүүгийн үйл ажиллагааны магадлан шинжлэлийг зохистой хийж чаддаггүй.
- Хэнтий аймаг Улаанбаатар хотод харьцангуй ойр, дэд бүтэц сайн хөгжсөн. Иймд ихэнх хүмүүс бүтээгдэхүүн, үйлчилгээг Улаанбаатар хотод очиж авдаг, зөвхөн бага хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтыг л орон нутагт хийдэг. Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, борлуулалтыг дэмжих зохицуулалтыг сайжруулах шаардлагатай.
- Хүний нөөцийн хомсдол нь бизнест саад болж байна. Хувийн хэвшилд ажиллагсдын цалин хөлс бага тул хүмүүс хувийн хэвшилд ажиллах

сонирхолгүй байдаг. Гэвч борлуулалт, зах зээлийн эрэлт доогуур учраас ажилчдын цалинг нэмэхэд хэцүү юм.

- Банкны зээлийн хүү өндөр байгаа нь бизнесийн хөгжилд саад болж буй бэрхшээл мөн.
- Томоохон хэмжээний компаниуд ажлын байр бий болгож, татвараа төлснөөр эдийн засгийг дэмжиж байгаа гэдгийг төр ойлгож, хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэвч аймгийн хэмжээнд хувийн хэвшлийг дэмжиж буй ихэнх дэмжлэг туслалцаа орон нутгийн хоршоо, холбоодод чиглэдэг учраас жижиг дунд бизнес орхигддог. Ихэвчлэн янз бүрийн төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг хоршоо, холбоо, өрхийн бизнес, жижиг бизнес нь тогтворгүй, үр дүнгүй байдаг.

Аялал жуулчлал

- Байгаль орчныг хамгаалах, бизнесийн хөгжлийг тэнцвэржүүлэх замаар эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь орон нутгийн хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой. Иймд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, дэд бүтцийн илүү их дэмжлэг шаардлагатай байна.

Эдийн засгийн өсөлт, ажлын байр

- Олон хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бусад шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа алдсан учраас ядуу байна. Гэвч зарим хүмүүс ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, санаачилгагүйн улмаас ядууралд өртөж байна. Ажилтай иргэд бус ядуу, ажилгүйчүүд нийгмийн халамжийн тэтгэмж авах эрхтэй байдаг учраас хүмүүс биеийн хүчний ажил хөдөлмөр эрхлэх сонирхолгүй, нийгмийн халамжийн тэтгэмж авахыг илүүд үздэг.
- Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөл хангагдсан байх ёстой. Жишээ нь халамжийн тэтгэмжийг бууруулж, нийтэд хавтгайруулан олгодог нийгмийн халамжийн тэтгэмжийг зогсоосноор иргэд ажил хөдөлмөр эрхлэх хөшүүрэг болно.
- Дээд боловсрол, ажлын байр, бүс нутгийн эдийн засгийн боломжийн уялдааг холбоог хангасан бүсийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Орон нутаг, аймгийн төвүүдэд их дээд сургуулиудын салбарыг нээснээр оюутнууд орон нутгийн хүн амын тоог нэмэгдүүлэх, орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулах, орон нутагт ажиллах зэргээр хувь нэмрээ оруулах боломжтой юм. Энэ нь ажилгүйдлийн асуудлыг ч шийдэхэд тусална.
- Хэнтий аймагт ажилгүйдэл их байгаа нь боловсруулах үйлдвэрлэл дутагдалтай байгаатай холбоотой.

Нийгмийн халамж

- Ажилгүйдэл, ядуурлын тодорхойлолтыг эргэн харж нийгмийн халамжийн тэтгэмжээс хэт хамааралтай байдлыг бууруулах нь зүйтэй.
- Нийгмийн халамжийн бодлого, үйлчилгээ нь хөдөө орон нутгийн түвшинд өөр байх ёстой.

<p>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн баримт бичигт тусгах санал</p>	<p>Салбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • ДБГ-ийн өмнөх санхүүжилтийн дэмжлэг ихэвчлэн төсвийн дэмжлэг, боловсролын салбарт чиглэсэн, хөдөө аж ахуйн салбарт томоохон дэмжлэг үзүүлээгүй. Цаашид ДБГ-ийн дэмжлэгийг хөдөө аж ахуйн салбарт чиглүүлэх нь зүйтэй. • ИНБ-уудын чадавхийг бэхжүүлэхэд ДБГ дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. • Зөвлөлдөх уулзалтын оролцогчид үндэсний түвшинд дараах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон: 1) банк, санхүүгийн салбар, ялангуяа зээлийн нөхцөл, бүх салбар, хувийн хэвшлийг дэмжих санхүүжилтын хүртээмжийг сайжруулах, 2) засаглал, 3) боловсрол, эрүүл мэнд, 4) хөдөө аж ахуй. • Зөвлөлдөх уулзалтын оролцогчид Хэнтий аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг үндэсний түвшний тэргүүлэх чиглэлтэй ижил тодорхойлсон. Зарим оролцогчид аялал жуулчлалыг Хэнтий аймгийн хөгжлийн 3 дахь тэргүүлэх чиглэл гэж тодорхойлсон.
<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> • Зарим оролцогчид ДБГ-ийн тухай болон түүний үйл ажиллагааны талаар мэдээлэл бага эсвэл огт мэддэггүй учраас ДБГ-ийн үйл ажиллагааны талаар илүү ихийг мэдэхийг хүсч байв. • Зарим оролцогчид өнгөрсөн хугацаанд ДБГ-ийн Монгол улстай хамтран ажилласан түншлэлийн стратегийн үр дүн, үнэлгээний талаар асууж тодруулсан.

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага, засаглал/шинэтгэл	7	44%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	7	44%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	5	31%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	5	31%
— Санхүүгийн зах зээл	4	25%
— Авилгатай тэмцэх	3	19%
— Эрүүл мэнд	3	19%
— Боловсрол	2	13%
— Байгалийн нөөцийн удирдлага	2	13%
— Хөдөөгийн хөгжил	2	13%
— Эдийн засгийн өсөлт	2	13%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	13%
— Хүнсний аюулгүй байдал	2	13%
— Гадаадын хөрөнгө оруулалт	2	13%
— Зам, тээвэр	2	13%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	1	6%
— Эрх тэгш боломжоор хангах	1	6%
— Уур амьсгалын өөрчлөлт	1	6%
— Бусад:	1 (хууль эрх зүй)	6%

— Худалдаа, экспорт	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Нийгмийн хамгаалал	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	7	44%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	5	31%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	5	31%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	5	31%
— Бүгд чухал	4	25%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	2	13%